

БАТЛАВ  
НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ  
ДАРГА Д.НАЦАГДОРЖ

Нийслэлийн Дотоод аудитын албаны 2015 оны үйл ажиллагааны үр дүнг  
үнэлсэн ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах  
хариу арга хэмжээний төлөвлөгөө

2016 оны 2 дугаар сар 18

№	Өгсөн зөвлөмж	Хариу арга хэмжээ	Хариуцах албан хаагч	Хэрэгжүүлэх хугацаа
1	Бодлогын баримт бичиг боловсруулахдаа төлөвлөлтийг оновчтой зөв томъёолох	Аудитын болон үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ хийхдээ төлөвлөлтийг зөв томъёолох	Хэлтсийн дарга нар	1 дүгээр улирал
2	Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, бодлогын болон захирамжлалын баримт бичгүүдийн хэрэгжилтийн тайлан, мэдээг гаргахдаа ажил үйлчилгээний тоо хэмжээ, зорилтыг хэрэгжүүлэхэд зарцуулсан зардлын мөнгөн дүн, гарсан бодит үр дүнг тусган хэмжиж, харьцуулж болох байдлаар боловсруулж байх	Байгууллагын 2016 оны үйл ажиллагааны тайлан, бодлогын болон захирамжлалын баримт бичгүүдийн биелэлтийг бодит үр дүнг тодорхой тоо хэмжээ, мөнгөн дүнтэй тусган, өмнөх жилийн үзүүлэлттэй харьцуулж гаргах	Хэлтсийн дарга нар	Тухай бүр
3	Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар бодлогын болон захирамжлалын баримт бичгүүдийн хэрэгжилт, үйл ажиллагааны тайлан мэдээ, цаг үеийн холбогдолтой асуудлыг ажил тус бүрээр нь хэлэлцэж хурлын тэмдэглэлээр баталгаажуулан хурлаас гарсан шийдвэрийн хамт хүргүүлэх	Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар үйл ажиллагааны тайлан, бодлогын болон захирамжлалын баримт бичгүүдийн биелэлт, цаг үеийн бусад асуудлыг дэгийн дагуу хэлэлцэж, хурлын тэмдэглэл хөтлөн албажуулж байх	Я.Сарансүх, Б.Солонгожаргал	Тухай бүр
4	Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан журмын 13.3 дах заалтын дагуу иргэдээс ирүүлсэн саналыг байгууллагын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх	Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хугацаанд нь шийдвэрлэх	Захиргаа, хуулийн хэлтэс	Тухай бүр

5	Байгууллагын даргын тушаалын үндэслэх хэсэгт хуулийн зүйл заалтыг буруу бичсэн, тушаал үг үсгийн алдаатай, тушаалд хамааралгүй хуулийн заалт үндэслэсэн, тушаалын тэргүү, хуулийн үндэслэх хэсэг, агуулга хоорондоо зөрүүтэй, тэргүү оновчгүй, тушаалын хавсралтын албан хэрэг хөтлөлтийн стандарт алдагдсан, хууль бус томилгоотой зэрэг зөрчлийг засаж ажиллах	Байгууллагын даргын 2015 оны алдаатай тушаал, тушаалын хавсралтын алдааг засаж залруулах, дахин давтан гаргахгүй ажиллах	Я.Сарансүх, Б.Солонгожаргал	1 дүгээр улирал
		Томилгоог хууль тогтоомжийн дагуу хийх	Д.Нацагдорж, Я.Сарансүх	Жилдээ
6	Байгууллагаас болон үндсэн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан тендер, сонгон шалгаруулалтын талаарх мэдээ, мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудсанд байршуулж хэвших	Худалдан авах ажиллагааны талаарх холбогдох мэдээ, мэдээллийг хууль тогтоомжийн дагуу байгууллагын цахим хуудсанд байршуулах	С.Болор-Эрдэнэ, тухайн үнэлгээний хороо болон ажлын хэсгийн нарийн бичгийн дарга	Тухай бүр